



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 27 өдөр


Дугаар A/18

Бор-өндөр сум

**Хариуцлагатай жижүүр
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 2025 оны Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын даргын "Чиглэл хүргүүлэх тухай" 148 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ;

1. Цагаан сарын баярын амралтын өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг хавсралтаар баталсугай.
2. Баярын өдрүүдэд яаралтай дуудагдах эмч, эмнэлгийн мэргэжилтэн нар гар утсаа нээлттэй байлгах, Хүлээн авах, яаралтай тусламжийн ээлжинд гарч буй сувилагч, эмч нар Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүрт хүснэгтийн дагуу үнэн зөв мэдээ өгөх, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой гарсан тулгамдсан асуудлыг Эмнэлзүй эрхэлсэн дарга (Ч.Мөнгөнчимэг)-т мэдэгдэх ажлыг үүрэг болгосугай.
3. Хариуцлагатай жижүүр эмч нар жижүүрийн мэдээ болон ажил хүлээлцсэн мэдээг Эмнэлзүй эрхэлсэн дарга /Ч.Мөнгөнчимэг/-т, ээлжийн сувилагч нар Сувлахуй албаны дарга /Д.Боргил/-д танилцуулж ажиллахыг үүрэг болгосугай.
4. Барилга байгууламжийн халаалт, шугам сүлээний хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг бүх хариуцлагатай жижүүрт үүрэг болгосугай.
5. Уг тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагаа эрхэлсэн дарга (Т.Баярчимэг)-т даалгасугай.

ДАРГА  А.БАТБААТАР

